



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 05 сарын 26 өдөр

Дугаар 251

Улаанбаатар хот

Удирдамж болгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6, 9 дэх хэсэг, 21 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Мэдээлэл, холбооны сүлжээ" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг удирдамж болгосугай.

1.1. Чулуунцэцэгийн Золбаяр нь өөр ажилд шилжин ажиллах болсон үндэслэлээр "Мэдээлэл, холбооны сүлжээ" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирлын албан тушаалаас чөлөөлөгдөх хүсэлтээ өгсөн тул үүрэгт ажлаас чөлөөлөх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх.

2. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ